



## “ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

№ 2025/1

Улаанбаатар хот

“Газар Шим Үйлдвэр” ХК -ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4-р сарын 19-ний өдрийн 11:00-12:30 цагийн хооронд Галлери Улаанбаатар төвийн 3 давхарт Sky ballroom танхим зохион байгуулагдлаа.

Хурлын даргаар Гүйцэтгэх захирал Ц.Ганбат ажилласан бөгөөд нээж үг хэлэв.

Хурлын ирцийг тооллогын комиссын дарга Д.Онон танилцуулсан бөгөөд “Газар Шим Үйлдвэр” ХК -ийн саналын эрхтэй нийт 1,198,113,207 ширхэг хувьцаанаас 67.1 хувь буюу **803,844,907** ширхэг хувьцаа эзэмшиж буй 57 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон тул хурлыг хүчин төгөлдөрт тооцсон тухай мэдэгдлээ.

Хурлын хэлэлцэх асуудал болон хурлын дэгийг Гүйцэтгэх захирал Ц.Ганбат танилцуулаа. Үүнд:

1. Компанийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайланг танилцуулж хэлэлцэн батлах;
2. Компанийн ТУЗ-ийн 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулж хэлэлцэн батлах;
3. Компанийн 2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах;
5. Компанийн дүрмийн төсөлд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж батлах зэрэг болно.

Үүний араас асуулт хариултын хэсэг өрнөсний дараа тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн хэлэлцэх асуудлуудад өгсөн санал хураалтын дүнг нэгтгэж танилцуулна.

Хэлэлцэх асуудлуудыг баталсан тул одоо та бүхэнд тайланг танилцуулъя.

2024 онд компанийн цэвэр борлуулалт ₮41 тэрбум болж 2023 оны мөн үеэс 20%-иар өссөн байгаа. Нөгөө талдаа борлуулсан бүтээгдэхүүний ч мөн тайлант хугацаанд 19% өсөж ₮23.6 тэрбумд хүрсэн. Ингэснээр 2024 оны нийт ашиг 2023 оныхоос 20% өсөж ₮17.46 тэрбум болсон. Үүнээс үйл ажиллагааны зардлуудаа хассанаар татвар төлөхийн өмнөх ашиг ₮8.99 тэрбум болсон билээ. Энэ дүнгээс ₮1.4 тэрбумын татвар хасагдсанаар 2024 оны татварын дараах цэвэр ашиг ₮7.56 тэрбум болсон байна. Энэ амжилт нь 2023 оныхоос 16% өссөн ийм үзүүлэлт билээ.

Компанийн тайлангийн нөхцөл байдлыг танилцуулахад, өмнөх хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн үндсэн хөрөнгийг зах зээлийн үнээр дахин үнэлж, тайланд тусгах саналыг хувьцаа эзэмшигчийн зүгээс тавьсан. Бид уг саналыг дагаж хөрөнгөө дахин үнэлүүлснээр компанийн тайлан баланс дээрх нийт өртөг нэлээд хэмжээгээр өссөн.

Үүний хүрээнд компанийн үндсэн үйл ажиллагааны гол үзүүлэлтүүдийг шинжилж, харьцуулсан байдлаар бүхэлд нь харахад дээр тайлбарласнаар борлуулалт 20%, цэвэр ашиг 16% тус тус



өссөн. Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд нь салбарын дундаж болон өмнөх онтой харьцуулахад өндөр байна.

Гэсэн хэдий ч нийт хөрөнгийн өгөөж (ROA) 12.3% болсон буюу өмнөх оныхоос 0.8 нэгж хувиар буурсан. Энэ нь хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой. Хөрөнгийн хэмжээ өссөн тул нийт хөрөнгийн өгөөжийн дүн буурсан. Энэ утгаараа эздийн өмчийн өгөөж өндөр ч буурсан. Гэсэн хэдий ч салбарын дунджаас харьцангуй өндөр байна.

Компанийн төлбөрийн чадвар 2023, 2024 онд салбарын дунджаас бага байсан. Гэхдээ 2024 онд төлбөрийн чадвар сайжирсан. Үүнд:

Өр төлбөр багассан,

Зээлийн эргэн төлөлт хугацаандаа, графикийн дагуу хийгдсэн (банкны зээлийг бүтээн байгуулалт, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлт, тоног төхөөрөмжийн сайжруулалтад зарцуулсан),

Ашигт ажиллагаа нэмэгдсэн зэрэг нь нөлөөлсөн.

Манай компанийн хувьд санхүүгийн хөшүүргийг харьцангуй бага ашигладаг нь төлбөрийн чадварт эергээр нөлөөлсөн. Хөрвөх чадвар харьцангуй сайн, өндөр байна.

Ногдол ашгийн бодлого

2024 оны үр дүнг ТУЗ дээр хэлэлцэж, нэгж хувьцаанд ₮2.6 буюу нийт ₮3.1 тэрбумын ногдол ашиг тараах шийдвэр гаргасан. Үүний үр дүнд хувьцааны өгөөж 5.2%-тай байна.

Бид 2024 онд хуримтлагдсан ашгийнхаа 40% гаруйг ногдол ашиг болгон тараасан. Харин 2023 онд цэвэр ашгийнхаа 86%-ийг ногдол ашиг болгон хуваарилсан байдаг. Харин одоо бид шинэ бүтээн байгуулалтаа дуусгаж, шинэ бүтээгдэхүүнүүдээ зах зээлд нэвтрүүлэх ажлаа дуусгасны дараа, 2025 оны үр дүнд үндэслэн ирэх жилийн ногдол ашгийн хэмжээг шийднэ.

Компани анх хөрөнгийн биржид бүртгүүлэхдээ ногдол ашгийн бодлогоо баталсан. Энэхүү бодлогын дагуу тухайн жилийн татварын дараах цэвэр ашгийн 30%-иас доошгүйг ногдол ашиг хэлбэрээр тараана гэж тусгасан. Энэ бодлогын дагуу эхний 2 жил өндөр түвшинд ногдол ашиг хуваарилсан.

Аудитын дүгнэлт

Бидний 2024 оны санхүүгийн тайланд аудит хийж, аудитын дүгнэлт бэлэн болсон байна. Аудит нь Газар Шим Үйлдвэр ХК-ийн 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, ашгийн ба алдагдлын тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн бодлого зэрэг тайланд хийгдсэн. Дүгнэлтээр, тус тайлангууд нь олон улсын санхүүгийн тайлагналын стандартад нийцсэн, үнэн зөв, бодитой байна хэмээн үнэлэгдсэн. Аудит нь олон улсын стандартын дагуу хараат бус байдлыг ханган, компаниас хараат бус байж, ёс зүйн шаардлагыг бүрэн биелүүлэн хийгдсэн. Өөрөөр хэлбэл, аудитаар зөрчил илрээгүй, тайлан батлагдсан.

2024 оны үйл ажиллагаа ба бүтээн байгуулалт

2024 онд бид дараах 5 үндсэн чиглэлд төвлөрсөн. Үүнд:

- 6 нэр төрлийн шинэ бүтээгдэхүүн боловсруулж зах зээлд нэвтрүүлэх
- Борлуулалтын системээ шинэчилж, компанийн борлуулалтын чадавхыг нэмэгдүүлэх
- Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангаж бүтээмжийг нэмэгдүүлэх



- Маркетингийн бодлого, стратегия шинэчлэх
- Бизнесээ тэлэх хөрөнгө оруулалт хийх

2023 онд хөрөнгийн биржээр дамжуулан ₮10.5 тэрбумыг татан төвлөрүүлж, түүнийгээ 4 үндсэн чиглэлд зарцуулахаар төлөвлөсөн. Үүний хүрээнд:

### **Хүнсний ногооны зоорь**

Барилгын ажил 89%-тай явагдаж байна. Барилгын ерөнхий төлөвлөгөө 2023 оны 8-р сард батлагдсан.

Барилга дууссан, одоо тоног төхөөрөмжийн суурилуулалт хийгдэж байгаа. Голланд Улсаас ногоо хадгалах тусгай орчны иж бүрэн систем нийлүүлэхээр гэрээ байгуулсан. 8-р сард тоног төхөөрөмж, мэргэжилтнүүд ирэх юм. Улмаар 9-р сард зоорь бүрэн ашиглалтад орно. Туршилтаар 2 боксод тус бүр 20 тн ногоог хадгалж байна.

### **Бүтээгдэхүүн хөгжүүлэлт**

Үндсэн тоног төхөөрөмжүүд бэлэн болсон. Савлагааны хэсэгт хүндрэл гарсан. Хуванцар сав, уутан савлагааны тоног төхөөрөмжийн асуудлууд гарсан. Гэхдээ шийдэл гаргаж уутан савлагааг сайжруулж, тоног төхөөрөмжид шинэчлэл хийж ажиллаж байна. Тоног төхөөрөмжийг 4 сарын 27 гэхэд бэлэн болгож, 5-р сарын дунд үеэс суурилуулна. Пет савлагаатай бүтээгдэхүүнүүд хэдийн зах зээлд гарсан, дэлгүүрүүдэд борлуулагдаж эхэлсэн.

### **2024 оны менежментийн үр дүн**

2024 онд бид үйлдвэрлэлийн менежментээ сайжруулж, үйлдвэрийн дотоод зохион байгуулалт болон хөдөлмөрийг хөнгөвчлөх тоног төхөөрөмжүүдийг нэмснээр бүтээмжийг мэдэгдэхүйц өсгөсөн. Үүний үр дүнд үйлдвэрлэлийн хүчин чадал сайжирч, бүтээгдэхүүний өртөг мэдэгдэхүйц буурсан. Хэдийгээр 2024 онд инфляц өндөр, цалингийн зардал өссөн, ажиллах хүчний олдоц хязгаарлагдмал, цахилгаан болон бусад зардлууд нэмэгдсэн нь өртөгт дарамт учруулсан ч бид бүтээмжийг нэмэгдүүлснээр өртгийг тодорхой хэмжээнд хянаж, зарим үзүүлэлтээр өртгийг бууруулж чадсан.

### **Борлуулалтын систем**

Урьдчилж захиалга авдаг систем рүү шилжсэн. Борлуулалтын ажилтнуудын тоог 2 дахин нэмэгдүүлсэн. Зах зээл хамрах хүрээ, хэрэглэгчтэй тулж ажиллах байдал сайжирснаар борлуулалт 20% өссөн. Ажиллах хүчний олдоц ба тогтворгүй байдал хүний нөөцийн олдоц тогтвор муу байгаа нь үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Энэ асуудлыг шийдэхэд бонусын системийг нэвтрүүлээд явж байгаагаас гадна 2025 оноос тодорхой бодлого хэрэгжүүлнэ.

### **Маркетингийн үйл ажиллагаа**

2024 онд манай компанийн маркетингийн үйл ажиллагаа эрчимтэй идэвхжиж эхэлсэн. Ялангуяа III болон IV улиралд бид компанийнхаа 25 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулсан. Үүнтэй зэрэгцэн бид ребрэндинг буюу брэнд шинэчлэлийн ажлыг эхлүүлсэн нь компанийн маркетингийн идэвхийг нэмэгдүүлэхэд чухал түлхэц болсон. Манай хуучин лого "Газар шим" гэсэн бичигтэй, тамганы хэлбэртэй байсан. Харин шинэчлэлийн хүрээнд логотоо илүү энгийн, уншихад ойлгомжтой, цэгцтэй болгож, "Газар шим" гэсэн үгийг тод, цэвэр бичгээр илэрхийлсэн. Үүн дээр нэмээд бид шинэ симболыг нэвтрүүлсэн. Энэхүү тэмдэг нь ургамал ургаж, үр жимс



боловсроод дахин ургах буюу байгалийн эргэлт, дахин төлжих үйл явцыг илэрхийлдэг. Энэ нь үр өгөөжтэй, мөн эрч хүчтэй, хөдөлгөөнтэй дүрслэлтэй, ирээдүйн хөгжлийг бэлгэдсэн утгыг агуулж байгаа юм. Мөн бид шинэ логондоо ногоон өнгийг шингээж өгснөөр, экологид ээлтэй, байгальтайгаа ойр болон эрүүл хүнс үйлдвэрлэх зорилго, үйл ажиллагаагаа шингээж чадсан.

### **ТУЗ-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН: ТУЗ-ИЙН ДАРГА Ш.АЛТАНБАГАНА**

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Газар Шим Үйлдвэр ХК нээлттэй компани болсноос хойш ТУЗ хоёр дахь жилдээ үйл ажиллагаа явууллаа. 2024 оны хувьд ТУЗ нь 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажилласан. 2024 оны 9 сард нэг гишүүн сонирхлын зөрчлийн хуулийн дагуу түр чөлөөлөгдсөн. ТУЗ нь хараат болон хараат бус гишүүдээс бүрддэг. Гол хувьцаа эзэмшигчдээс гадна хараат бус гишүүдийн дунд хууль, эдийн засаг, санхүү, маркетинг, стратегийн чиглэлийн мэргэжилтнүүд ажилласан.

ТУЗ-ийн үндсэн үүрэг нь ХК-ийн засаглалын тэнцвэртэй байдлыг хангаж, компанийн стратеги, гүйцэтгэлд хяналт тавих, удирдлагын тайланг хэлэлцэх, шаардлагатай зөвлөмж, дүгнэлт гаргах явдал байсан. Хурлын бус цагаар хороодоор дамжуулан идэвхтэй ажилласан.

2024 оны хуралдааны мэдээлэл:

Ээлжит хурал – 4 удаа,

Ээлжит бус (онлайн) хурал – 2 удаа,

Нийт хурал – 6 удаа,

Гаргасан тогтоол, шийдвэр – 17 байсан ба шийдвэрийн дийлэнх нь засаглалыг сайжруулах чиглэлийн журам байсан.

Хуралд оролцох боломжийг биет болон цахимаар шийдсэн тул гишүүд бүх хуралд 100% ирцтэй оролцсон.

Хороодын үйл ажиллагаа:

Маркетинг, борлуулалтын хороо – Үйл ажиллагаатай танилцаж зөвлөмж гаргасан

Нэр дэвшүүлэх хороо – Шинэ гишүүн, нарийн бичгийн томилгоонд ажилласан

Санхүүгийн аудитын хороо – Хөндлөнгийн аудитын сонгон шалгаруулалт, санхүүгийн дүгнэлтүүдэд оролцсон

Өмнө нь дурдсанчлан хараат бус гишүүн Эрдэнэдалай (Дэлгэрдалай) өөрийн хүсэлтээр түр чөлөөлөгдсөн байгаа. 2024 онд ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар П.Нямдорж шинээр томилогдсон.

### **Үйл ажиллагааны дүгнэлт**

2024 оны эхний улиралд туз ээлжит хурлаараа компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг хэлэлцэж, “хангалттай үр дүнтэй” ажилласан гэж дүгнэсэн. хк болсон 2023 оноос хойш амласан бүтээн байгуулалт, өөрчлөлтүүдийн гүйцэтгэл 100%-д хүргэсэн. түүнчлэн борлуулалт болон ашигт ажиллагаа өссөн. Шинэ бүтээгдэхүүнүүд дөнгөж зах зээлд нэвтэрч, тоног төхөөрөмжүүдийн асуудал жигдрээгүй байгаа ч борлуулалтын орлого нэмэгдсэн. 2025 оноос үр дүнгээ илүү үзүүлнэ гэсэн хүлээлттэй байна.



Санхүүгийн үзүүлэлтүүд дундаа өр, төлбөрийн харьцаа, зардлын хяналт, харьцаа үзүүлэлт зэрэг нь эрүүл түвшинд байгаа тул үүний “хангалттай” гэж дүгнэж байна.

Аудитын дүгнэлт эерэг гарсан.

2025 оны ТУЗ-ийн төсөв

2025 оны ТУЗ-ийн төсөв ₮178.1 саяар батлагдсан. Жишгийн дагуу төсвийн дийлэнх зардлыг цалингийн зардал эзэлж байна. Тодруулбал, 2025 оны ТУЗ-ийн нийт цалингийн зардал ₮156.2 сая. Хурлуудын зардлыг хэмнэх үүднээс цахим хэлбэрээр явуулахыг зорьж, зардлыг оновчтой төлөвлөсөн.

## **ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ц.ГАНБАТ**

### **Компанийн дүрмийн өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэх нь:**

Компанийн үйл ажиллагаанд шаардлагатай шил, сав, баглаа боодол болон түүхий эдийг ихэвчлэн гадаадаас татан авдаг. Үүнээс хамгийн их зардалтай хэсэг нь сав, баглаа боодлын тээвэрлэлт юм. Манай компани өөрийн автомашинаар тодорхой хэсгийг тээвэрлэдэг бөгөөд үлдсэн хэсгийг гаднын байгууллагаар гэрээний үндсэн дээр тээвэрлүүлдэг. Гэвч өөрийн машинаар ачаа тээвэрлэх явцад гааль, хилийн хяналт, хорио цээрийн байгууллагуудаас хүндрэл гарч байна. Учир нь компанийн дүрэмд ачаа тээвэрлэх чиглэлийн үйл ажиллагаа тусгагдаагүй байдаг. Иймд бид компанийн дүрмийн 3.1.12 дахь заалтад “авто тээврээр ачаа тээвэрлэх” чиглэлийг нэмэх саналыг оруулж байна. Энэхүү дүрмийн нэмэлт өөрчлөлтийг дэмжиж баталж өгөхийг хувьцаа эзэмшигчдээс хүсье.

Асуулт-хариултын хэсэг

Асуулт хариултын хэсгийг Гүйцэтгэх захирал Ц.Ганбат удирдаж, хариулж оролцов.

Хувьцаа эзэмшигч Болд: Түүхий эдийн бэлтгэл, явцын тухайд:

Гүйцэтгэх захирал Ц.Ганбат

Манай компани ногооны үйлдвэрлэлд анх өөрсдөө оролцож, хоёр жилийн турш тарьж үзсэн. Гэвч энэ нь нарийн зохион байгуулалт, цаг үеэ олсон арчилгаа шаарддаг төвөгтэй ажил тул орон нутгийн ногоочидтой хамтрах стратегид шилжсэн. Бид тэдэнтэй гэрээ байгуулан, чанарын шаардлага тавьж, шаардлагатай түүхий эдээ тогтмол нийлүүлдэг системийг бүрдүүлсэн. Харин бид өөрсдөө Зүүнхараад байрлах органик фармдаа бид “артишок” тариалж, органик батламжтай бүтээгдэхүүн болгон боловсруулж, зах зээлд нийлүүлж байна. Мөн судалгаа, туршилтын ажлууд хийж, ногоочдыг дэмжих зорилгоор сургалт, шинэ технологи, арга барил нэвтрүүлэхэд хөрөнгө зарцуулсан. 2021–2022 онд өргөст хэмхийн ургацыг нэмэгдүүлэх чиглэлээр ₮150 сая орчмын санхүүгийн дэмжлэг үзүүлснээр нэгж талбайгаас авах ургац 2 дахин нэмэгдсэн. Үүний үр дүнд бид 2023–2024 онд 1,400–1,500 тн өргөст хэмх хураан авсан.

Хувьцаа эзэмшигч Жавхлан : Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үйлдвэрийн талаар:

Гүйцэтгэх захирал Ц.Ганбат:

Шинэ үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглаж байна. Одоогоор нийт 4 шугамаар үйлдвэрлэл явуулж байгаа бөгөөд үйлдвэрлэлийн ачаалал 80%–90%-тай байна. Шинэ бүтээгдэхүүний шугамуудын хувьд эхлэл төдий учраас хүчин чадлын 5%–10%-ийг л ашиглаж байгаа.



Шинэ бүтээгдэхүүн гаргахдаа бид дотоодын хэрэглэгчийн хэрэгцээ, зах зээлийн чиг хандлага болон өрсөлдөгчдийн судалгаанд үндэслэж шийдвэр гаргадаг. Үүний тулд хөндлөнгийн байгууллагууд (MMCG, Consumer Insight гэх мэт) болон манай маркетингийн албаны судалгааг ашигладаг.

Зарим бүтээгдэхүүн төлөвлөгөөнд байгаагүй ч, технологийн боломж гарсан үед зах зээлд нэвтрүүлсэн. Жишээлбэл, 2025 оны 4 сард паста соусыг шинээр үйлдвэрлэж, худалдаанд гаргасан.

Онлайнаар ирсэн асуулт: Зах зээл дэх байр суурь, өрсөлдөөний талаар:

Гүйцэтгэх захирал Ц.Ганбат:

Ковид-19-ийн дараа барааны хомсдол, түүхий эдийн хязгаарлалт зэрэг хүндрэл гарч байсан ч, 2023–2024 он гэхэд манай үйл ажиллагаа тогтворжсон. 2024 оны судалгаагаар манай компани жимс, хүнсний консервын зах зээлийн 28%-ийг эзэлж, салбартаа тэргүүлж байна.

Өрсөлдөгчдийн хувьд: Импортын бүтээгдэхүүнүүд гол өрсөлдөгч болж байна. Дотоодын хоёр том үйлдвэрлэгч, тухайлбал Багро компани нь сүүлийн жилүүдэд идэвхтэй сурталчилгаа, хөнгөлөлт, урамшуулал бүхий борлуулалтын стратеги хэрэглэж байна.

Бид 2025 оны борлуулалтын оргил үе буюу Цагаан сарын үеэр манай өрсөлдөгчид маш олон төрлийн маркетинг хийж, хөнгөлөлт олгож байсан. Гэсэн ч бид үүний эсрэг тус хугацаанд ₮7.2 тэрбумын борлуулалт хийж, зах зээл дээрх байр сууриа хадгалаад зогсохгүй баталгаажуулж чадсан. Шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэхийн хэрээр өрсөлдөгчид маань нэмэгдэхээр байна. Гэсэн ч бид байр сууриа хадгалж, шинэ бүтээгдэхүүний зах зээлд хүч түрэн орох зорилготой байна.

Хувьцаа эзэмшигч Цэцэгээ: Шинэ үйл ажиллагааны чиглэл орлогод нөлөөлөх талаар төсөөлөл:

Гүйцэтгэх захирал Ц.Ганбат:

Юуны түрүүнд үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлж нь орлого өсгөх гэхээс илүү үйл ажиллагааг тогтворжуулахад нөлөөтэй. Үүнд: Шил сав, баглаа боодлын тээврийн зардлыг бууруулах зорилгоор өөрийн ачааны машинтай болсон. Голланд Улсаас зориулалтын, улиралд тохирсон (өвөл хөлдөхгүй, зун халуунд тэсвэртэй) шинэ тээврийн автомашин авахаар болсон.

Ингэснээр гэрээт борлуулагчид руу бараа бүтээгдэхүүн хүргэх нөхцөл сайжирна.

Эдгээр шинэ үйл ажиллагааг дүрэм, журамдаа тусгаж байгаа бөгөөд энэ нь цаашдын тогтвортой ажиллагаанд чухал нөлөөтэй.

Хувьцаа эзэмшигч Ганбаяр: Компанийн хувьцааны идэвхжилт сул байгаа. Үүнийг сайжруулахын тулд компанийн зүгээс ямар бодлого, арга хэмжээ төлөвлөж байгаа талаар:

Гүйцэтгэх захирал Ц.Ганбат:

Бид хувьцаа эзэмшигчдийн үнэлэмж, ханшийн хөдөлгөөнд ач холбогдол өгдөг. Хувьцааны идэвхийг нэмэгдүүлэх хүрээнд нэмэлт хувьцаа гаргах, халаасны хувьцаа худалдан авах зэрэг арга замыг судалж байна. Мөн андеррайтер компанитайгаа хамтран зах зээлийн оролцоог



сайжруулах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх боломжуудыг хэлэлцэж байгаа. Шийдвэр гарсан тохиолдолд хувьцаа эзэмшигчдэд цаг тухайд нь мэдээлнэ.

Хувьцаа эзэмшигч Энхбат: Хүний нөөцийн бодлого, ялангуяа тогтвор суурьшил, цалин, нийгмийн даатгалын асуудлууд дээр ямар бодлого баримталж байгаа тухайд

Гүйцэтгэх захирал Ц.Ганбат:

Манай компанийн цалингийн зардал 2024 онд огцом өссөн. Манай компанийн ажилтнуудын дундаж цалин нь салбарын дунджаас 30% өндөр байгаа бөгөөд 2024 оны гүйцэтгэлээр нийт цалингийн хэмжээ 80% орчим нэмэгдсэн. Мөн Нийгмийн даатгалд бүрэн хамруулсан бөгөөд нэг ч удаа хугацаа хэтрүүлэлгүй, бүрэн төлбөрөө хийдэг. 2025 онд ч зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч бид цалингаа нэмэх нөхцөл үүсэж байна.

Хүний нөөцийн тогтвор суурьшлыг хангах үүднээс 5 жилийн хуримтлалын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа. Уг хөтөлбөрт бидний итгэлийг олсон 60+ ажилтан хамрагдаад байна. Ажилтан 5 жил тогтвортой ажилласан тохиолдолд хуримтлал бүрэн олгогдох, 1 жил ажилласан бол 20%-ийг нь авах боломжтой. Зарим ажилтны хуримтлал ₮40 сая хүрэхээр байна. Энэ нь ажилтны хувьд маш том хөшүүрэг болж үр дүн гаргаж байна.

Борлуулалтын албаны тогтворгүй байдал, удирдлагын давтамжтай солигдолт зэрэг сорилтуудыг даван туулж, 2024 оны 11-р сараас үйл ажиллагаа тогтворжиж эхэлсэн. 2025 оны II улирлаас борлуулалтын үйл ажиллагаа үр ашигтай явагдана гэж үзэж байна.

Хувьцаа эзэмшигч Батбаяр: Хувьцааны ханш бууралт, хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлын талаар тайлбар өгнө үү.

Манай хувьцаа анх ₮53-өөр гарч байсан бол сүүлийн 2 жилд ₮48-₮49-ийн хооронд хэлбэлзэж, ногдол ашиг хуваарилах өдрөөс хойш ₮1-₮2-өөр буурч, ₮45-₮46-т тогтсон. Хэдий ашигтай ажиллаж байгаа ч бидний хийсэн хөрөнгө оруулалтуудын үр өгөөж 2-3 жилийн хугацаанд бүрэн мэдрэгдэх учир ханшид нөлөөлөхөд хугацаа шаардлагатай.

2023 онд бид ТОП-20 индексийн багцад орж байсан бол 2024 онд арилжааны идэвх буурснаас үүдэн жагсаалтаас хасагдсан. Түүнчлэн, Монголын хөрөнгийн зах зээл жижиг, хөрвөх чадвар сул, шинэ хувьцаа эзэмшигч татах орчин бүрэн төлөвшөөгүй байгааг анхаарах нь зүйтэй.

Хувьцаа эзэмшигч Энхмэнд: 2025 оны борлуулалт болон цэвэр ашгийн төлөвлөгөө, 2025 оны I улирлын гүйцэтгэл төлөвлөгөөндөө нийцсэн эсэх талаар:

2025 оны хувьд бид амбицтай зорилт тавин ажиллаж байгаа. Төлөвлөгөө маань ТУЗ-өөр батлагдсан бөгөөд борлуулалтыг өмнөх оноос ойролцоогоор 30% өсгөх зорилт тавьсан.

2025 оны I улирлын гүйцэтгэлийн хувьд, бид нийт төлөвлөгөөний 98%-ийг биелүүлсэн нь бидний хувьд сайн амжилт гэж үзэж байна. Гэвч жилийн эхэнд төлөвлөж байсан зарим шинэ бүтээгдэхүүнээ хугацаандаа зах зээлд гаргаж чадаагүй, үүний улмаас тодорхой хэмжээнд



төлөвлөгөөний биелэлтэд нөлөөлсөн. Гэсэн хэдий ч II улиралд эдгээр бүтээгдэхүүнүүд зах зээлд гарч, борлуулалтын багийн ажиллагаа улам сайжирч байгаа тул бид 2025 оны төлөвлөгөөг бүрэн хэмжээнд биелүүлнэ гэж итгэж байна.

Ингээд асуулт хариултын хэсэг өндөрлөж саналын цаг эхлэв. Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид 20 минутын хугацаанд хурлаар хэлэлцэж буй асуудлуудад саналаа өгсний дараагаар тооллогын комиссоос саналын үр дүнг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Д.Онон: "Газар Шим Үйлдвэр" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бүртгэлийн тооллогын комиссын шийдвэр 2025 оны 4 сарын 19-ний өдрийн тогтоол, Газар Шим Үйлдвэр ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлаар санал өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналыг үндэслэн шийдвэрлэх нь. Хурлаар дараах асуудлыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

Нэг: Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан тайланг хэлэлцэн батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99% санал өгснөөр хүчтэй санал өгсөн, нийт хувьцаа эзэмшигчдийн 99.999% зөвшөөрсөн байна.

Хоёр: Компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэн батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99% нь санал өгсөн. Санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.999% нь зөвшөөрсөн.

Гурав: Компанийн 2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99% нь санал өгч 99.999% зөвшөөрсөн байна.

Дөрөв: Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах тухай асуудалд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99.99% саналаа өгч 99.998% нь зөвшөөрсөн байна.

Тав: Компанийн дүрэм өөрчлөлт оруулах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99% нь санал өгч 99.999% зөвшөөрсөн байна. Ийнхүү тооллогын комисс шийдвэрээ танилцууллаа.

ХЭХ-ийн тогтоолуудыг ТУЗ-ийн НБД П.Нямдорж уншиж танилцууллаа.

Тогтоол №1

Компанийн 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн аудитын тайланг батлах тухай

Үндэслэл: Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт, ХЭХ-ын санал хураалт болон тооллогын комиссын дүн.

Тогтоох нь: Газар Шим Үйлдвэр ХК-ийн 2024 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланг хангалттай гэж үзэн баталсугай.

ХЭХ-ын дарга: Ц.Ганбат

Тогтоол №2



ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон 2025 оны төсвийг батлах тухай

Үндэслэл: Компанийн тухай хуулийн 62.1.15 дахь заалт

Тогтоох нь:

ТУЗ-ийн 2024 оны тайланг хангалттай гэж үзэн баталсугай.

ТУЗ-ийн 2025 оны төсвийг баталсугай.

ХЭХ-ын дарга: Ц.Ганбат

Тогтоол №3

2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Үндэслэл: Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт

Тогтоох нь: 2024 оны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.

ХЭХ-ын дарга: Ц.Ганбат

Тогтоол №4

Үйл ажиллагааны чиглэл нэмэх тухай

Үндэслэл: Компанийн тухай хуулийн 61.1.5, 62.1.1, 62.1.15 дахь зааль компанийн дүрмийн 4.8.7.1 дэх заалт

Тогтоох нь:

Компанийн үйл ажиллагааны чиглэлд “автотээврээр ачаа тээвэрлэх” чиглэл нэмсүгэй.

Үүнтэй холбогдуулан компанийн дүрмийн өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

Дүрмийн нэмэлтийг УБЕГ, СЗХ дээр холбогдох байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал Ц.Ганбатад даалгасугай.

ХЭХ-ын дарга: Ц.Ганбат

Эцэст нь, 2025 оны ээлжит хурлын санал хураалтын дүнг албан ёсоор баталж, хурлыг хаав. Хурлын төгсгөлд Газар Шим Үйлдвэр ХК-ийн Үйлдвэр хариуцсан захирал, Ерөнхий технологич Ц.Төгсөө зах зээл дээр шинээр худалдаанд гаргахаар хөгжүүлэлт хийж буй Шимт хүүхдийн жимс ногооны нухаш, майонез, кетчүр, хасага соус, чили соусны онцлогийн талаар мэдээлэл хүргэж, хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч нарт шинэ бүтээгдэхүүний дээжээс гардууллаа. Хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлснээр 12:30 цагт хурал өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн:

П.Нямдорж /ТУЗ-ийн НБД/

Танилцсан:

Ц.Ганбат /Хурлын дарга, Гүйцэтгэх захирал/